



**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар 8.3.1, 8.4, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 заалт, 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх хэсэг, "Босго үнэ шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ажлын байрны сонгон шалгаруулалт зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулан ажиллахыг Үнэлгээний хороо (Л.Намхайноров)-нд үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хороонд ажиллах ажилтнуудын "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл"-ийг гаргуулан байгууллагын ЭБАТ-д бүртгүүлж, худалдан авах ажиллагаатай холбогдох баримт бичгээр архивын нэгж үүсгэж, холбогдох албан тушаалтад хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Р.Энхсүрэн)-д үүрэг болгосугай.

ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Д.УРАНЗАЯА



142022 01018